

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянтал сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГСА-2024/02/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Говьсүмбэр аймаг  
2023 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа  
Утас: 70543179  
Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn  
Аудитын менежер: Г.Наранбаяр  
Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn  
Аудитор: Г.Ариунцэцэг  
Цахим хаяг: Ariuntsetsegg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ..	7
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	7
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	8
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	21
4.1 Ерөнхий зүйл.....	21
4.2 Материаллаг байдал .....	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	22
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	22
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	23
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	23
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	24
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	26

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АИТХ	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ГХУС	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
АО	Ажил олгогч



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг  
Утас/Факс: 976-7054 3179  
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЯНТАЛ  
СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН  
ЗАХИРАГЧ Б.ГАНБАЯР ТАНАА**

2024.03.25 № 51  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Говьсүмбэр аймгийн Баянтал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Баянтал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 71,730.2 мянган төгрөгийн зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

008020141

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### **Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баянтал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь ТЭЗ-тай байгуулсан жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө 6 зорилт 141 арга хэмжээг тусгаж Говьсүмбэр аймгийн Засаг даргаар батлуулсан бөгөөд жилийн эцсийн байдлаар 80 хувьтай дүгнэгдсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/ мянган  
төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		517,256.6	874,492.4
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	3а, 3б	130,406.8	352,075.4
32	<b>БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	4а, 4б	0.0	0.0
33	<b>АВЛАГА</b>	5а, 5б, 6а, 6б	220,753.3	211,486.3
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	7а, 7б	218.7	218.7
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	8а, 8б, 8в	152,145.3	187,275.6
36	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	9а	13,732.5	123,436.5
360	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	10	0.0	0.0
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		1,340,001.6	1,459,023.0
37	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	11а, 11б	0.0	0.0
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	12а, 12б, 12в	1,340,001.6	1,459,023.0
39100	Газар		0.0	0.0
39200	Биет хөрөнгө		1,261,028.6	1,380,200.0
39300	Биет бус хөрөнгө	13	78,973.0	78,823.0
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14	0.0	0.0
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		1,857,258.2	2,333,515.3
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		1,264.1	2,893.7
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	15а, 15б	1,264.1	2,893.7
41200	Богино хугацаат зээлийн өглөг	16а, 16б	0.0	0.0
41300	Өглөг	17а, 17б	1,264.1	2,893.7
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	0.0	0.0
42100	Урт хугацаат үнэт цаас	19	0.0	0.0
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	0.0	0.0
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		1,855,994.0	2,330,621.6
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		1,855,994.0	2,330,621.6
51100	Засгийн газрын оруулсан капитал		756,504.8	756,504.8
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		353,922.8	828,550.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		745,566.4	745,566.4
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		1,857,258.2	2,333,515.3

**2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан**

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>		1,340,160.4	1,885,385.2
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>		180,969.3	219,867.7
110	Орлогын албан татвар		130,713.1	173,685.1
1100	Хувь хүний орлогын албан татвар		130,713.1	188,609.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		0.0	-14,924.6
113	Хөрөнгийн албан татвар		22,918.1	15,298.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж		27,338.2	30,884.4
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	1а, 1б	120,961.6	162,452.9
120	Нийтлэг татварын бус орлого		120,961.6	162,452.9
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		1,038,229.5	1,503,064.5
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	2а, 2б	1,279,524.0	1,376,364.7
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		1,279,524.0	1,376,364.7
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		817,731.0	1,332,199.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		269,291.9	461,303.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		34,985.0	59,358.3
2103	Байр ашиглалттай хөлбоотой тогтмол зардал		82,576.6	92,487.3
2104	Хангамж, бараа материалын зардал		180,437.1	92,514.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		7,200.0	6,520.4
2107	Төмилөлт, зочны зардал		1,891.8	5,704.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		27,925.2	441,925.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		213,423.3	172,386.3
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		461,793.0	44,165.0
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>		60,636.4	509,020.4
V	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		2,749,400.9	34,392.8
VI	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>		-2,688,764.5	474,627.6

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**

*/мянган төгрөгөөр/*

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	1,262,026.6	1,779,848.2
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	180,969.3	219,867.7
110	Орлогын албан татвар	130,713.1	173,685.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	130,713.1	188,609.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-14,924.6
113	Хөрөнгийн албан татвар	22,918.1	15,298.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	27,338.2	30,884.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	14,006.6	11,915.4
1181	Газрын төлбөр	13,230.3	6,523.8
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	101.2	12,445.2
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	47,572.8	56,916.0
120	Нийтлэг татварын бус орлого	47,572.8	56,916.0
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	1,033,484.4	1,503,064.5
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,001,307.3	1,232,657.2
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,001,307.3	1,232,657.2
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	931,424.4	1,131,736.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	307,834.4	457,511.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,914.1	56,475.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	457,321.7	95,576.2
2104	Хангамж, бараа материалын зардал	18,254.9	24,958.9
2105	Нормативт зардал	0.0	533.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,669.4	11,707.0
2107	Томилолт, зочны зардал	1,891.8	5,704.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,511.9	459,352.8



"Баянтал сумын Засаг дарга"-ын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,026.2	19,917.9
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,882.9	100,920.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	260,719.2	547,191.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	150,374.4	323,322.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	150,374.4	323,322.4
2200	Дотоод эх үүсвэрээр	150,374.4	323,322.4
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-150,374.4	-323,322.4
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-87,935.0	-2,200.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	87,935.0	2,200.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	22,409.8	221,668.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	107,997.1	130,406.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	130,406.8	352,075.4

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,695,466.8	0.0	4,695,466.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-150,708.4	0.0	-150,708.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,544,758.5	0.0	4,544,758.5
9	Тайлант үеийн үр дүн	-2,688,764.5	0.0	-2,688,764.5
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,855,994.0	0.0	1,855,994.0
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,855,994.0	0.0	1,855,994.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,855,994.0	0.0	1,855,994.0
19	Тайлант үеийн үр дүн	474,627.6	0.0	474,627.6

"Баянтал сумын Засаг дарга"-ын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	2,330,621.6	0.0	2,330,621.6
----	--------------------------------------	-------------	-----	-------------

**2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,837,938.1	1,551,164.4	286,773.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,287,966.4	1,228,235.0	59,731.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,182,032.0	1,127,380.2	54,651.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	482,631.0	457,511.5	25,119.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,367.1	56,474.9	3,892.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	498,116.0	475,144.8	22,971.1
2104	Хангамж, бараа материалын зардал	23,074.0	23,073.9	0.0
2105	Нормативт зардал	533.0	533.0	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,300.0	28,299.4	0.0
2107	Томилолт, зочны зардал	6,477.0	5,704.0	773.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,413.3	61,520.6	1,892.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,120.6	19,117.8	0.2
211	ХҮҮ	0.00	0.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	105,934.4	100,854.8	5,079.5
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	30,500.0	25,498.4	5,001.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	75,434.4	75,356.4	78.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	489,411.8	320,729.4	168,682.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	60,559.9	2,200.0	58,359.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,837,938.1	1,665,502.2	172,435.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	401,145.6	395,417.0	5,728.6
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,278,466.4	1,213,178.3	65,288.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	158,326.1	56,906.8	101,419.2

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,017,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,017,000.00

**"Баянтал сумын Засаг дарга"-ын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>6,949,126.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,885,000.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,264,126.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,264,126.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>800,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	800,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>67,874.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>66,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	66,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,874.00</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	1,874.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>7,017,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>7,017,000.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,017,000.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Баянтал сумын Засаг даргын эрхэм зорилго нь "Хүний хөгжилд суурилсан эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлж, олон улсын чанарт нийцсэн төрийн үйлчилгээг иргэдэд мэргэжлийн түвшинд, ил тод, шуурхай, хүртээмжтэй хүргэж, тасралтгүй хөгжсөн байгууллага байх" юм.

Зорилтын хүрээнд ТЕЗ-тай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилт 141 арга хэмжээг төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 80%-тай дүгнэгджээ.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

"Баянтал сумын Засаг дарга"-ын харьяанд дотоод аудитын чиг үүрэг бүхий бүтэц байхгүй байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянтал сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баянтал сумын Засаг дарга нь Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2018 оны А/167 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж байна. Хууль, тогтоомж дүрэм, журам зааврын шинэчлэлд нийцүүлэн НБББББ-ийг шинэчлэх шаардлагатай байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Баянтал сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэх зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

#### **3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт**

"Баянтал сумын Засаг дарга"-ын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 476.3 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансдуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 130.4 сая, эцсийн үлдэгдэл 352.0 сая төгрөг болж, 221.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	-	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	130.4	352	221.6	62.9
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-	-
Хадгаламж	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>130.4</b>	<b>352</b>	<b>221.6</b>	<b>62.9</b>

Эх сурвалж: "Баянтал сумын Засаг дарга"-ын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 352.0 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна.

Замд яваа мөнгөн хөрөнгө дансанд эхний, эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Хадгаламж дансанд эхний, эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

#### Аудитын илрүүлэлт:

Байгууллагын Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдлийн баталгааг даргаар баталгаажуулаагүй, хянуулаагүй, хянагдаагүй дансны үлдэгдлийг Сумын санхүү алба тамга тэмдэг дарж баталгаажуулсан, дотоод хяналт сул зөрчилд зөвлөмж өгсөн. /ИТХ/

Сумын ИТХ-ын тогтоолоор батлагдсан дүнгээс хэтрүүлж гэрээ байгуулсан. Үүнд: Соёл урлаг, спорт заалны зураг төсвийн ажлын төсөв 8,000.0 мянган батлагдсан байхад 32,000.0 мянган төгрөгөөр, 04-06 дэд станц, цахилгааны шугамын зураг төсвийн батлагдсан төсөв 8,107.2 мянга байхад 19,985.7 мянган төгрөгөөр гэрээ байгуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн. /ОНХС-35.8 сая/

### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 220.8 сая, эцсийн үлдэгдэл 211.4 сая төгрөг болж, 9.3 сая төгрөгөөр буурсан байна. Авлага дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.0	0.0	0.0
Төлбөртэй үйлчилгээний авлага	0.0	0.0	0.0
Татаас, санхүүжилтийн авлага	0.0	0.0	0.0

**"Баянтал сумын Засаг дарга"-ын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Зээлийн хүүгийн авлага	7.5	2.4	-5.1
Бусад авлага	213.2	209	-4.2
Зээлийн авлага	0.0	0.0	0.0
<b>Дүн</b>	<b>220.8</b>	<b>211.4</b>	<b>-9.3</b>

*Эх сурвалж: "Баянтал сумын Засаг дарга"-ын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлага дансны үлдэгдэлд ИТХ-аас хууль, журам зөрчиж Ж.Цэвээндуламд тэтгэмжээр олгосон 31.5 сая төгрөг, ХХС-гийн үндсэн болон зээлийн хүүгийн авлага 150.9 сая, ЗДТГ-ын 2013 онд үүссэн хувь хүмүүсээс авах авлага 3.4 сая, ОНХС-ийн 2013 онд үүссэн байгууллагаас авах авлага 9.5 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд ХХС-гийн 150.9 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Баянтал сумын ХХС-гаас зээл авсан 9 зээлдэгчийн 150.9 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байна. Үүнд: 2022 онд авсан зээлдэгч Оорцог элгэн хоршоо 86 сая төгрөг, 2021 оны зээлдэгч П.Оюунбилэг 34.9 сая төгрөг, 2013-2019 оны 7 зээлдэгч 30 сая төгрөгийн хугацаа хоцорсон зээлтэй байгаа бөгөөд ШШГГ-т шилжүүлсэн байна.

**Аудитын илрүүлэлт:**

ИТХ-ын тогтоолоор баталсан дүнгээс хэтрүүлж гэрээ байгуулж зураг төсвийн ажилд урьдчилан мөнгө шилжүүлсэн боловч дараа оны тогтоолд тусгаж батлуулаагүй 2 ажлыг аудитын явцад авлага үүсгэж залруулсан. /ОНХС 16.1 сая/

Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын тогтоолоор баталсан журмыг зөрчиж, төрийн жинхэнэ албан хаагч болоогүй, үүрэг гүйцэтгэгчээр томилогдон ажиллаж байсан Ж.Цэвээндуламд Төрийн албанаас чөлөөлөгдөөгүй байхад анхан шатны баримтын бүрдэлгүйгээр /олгосон тэтгэмжийн тооцоолол, нийгмийн даатгалын тэтгэвэр тогтоосон баримтуудыг хавсаргаагүй/ тэтгэмж олгож төрд хохирол учруулсан зөрчлийг аудитын явцад авлага үүсгэж залруулсан. /ИТХ 31.5 сая/

**3.5.3 Урьдчилгаа**

Урьдчилгаа дансны үлдэгдэл 0.2 сая төгрөг байгаа нь ЗДТГ-ын цалингийн урьдчилгааны авлага байна.

**3.5.4 Бараа материал**

Бараа материалын эхний үлдэгдэл 165.8 сая, эцсийн үлдэгдэл 310.6 сая төгрөг болж, 144.8 сая төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл**

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	25.4	25.4	0.0
Эм боох материал	0.0	0.0	0.0
Бичиг хэргийн материал	1.2	1.2	0.0
Аж ахуйн материал	20.4	22.4	2.0
Сэлбэг хэрэгсэл	0.0	0.0	0.0
Түлш, шатах тослох материал	0.0	0.0	0.0
Барилгын засварын материал	0.4	0.0	-0.4

**"Баянтал сумын Засаг дарга"-ын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Хүнсний материал	0.0	0.0	0.0
Бусад хангамжийн материал	104.7	138.2	33.5
Мал амьтад			
Нөөцийн бараа	13.7	123.4	109.7
<b>Дүн</b>	<b>165.8</b>	<b>310.6</b>	<b>144.8</b>

Эх сурвалж: "Баянтал сумын Засаг дарга"-ын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэлд нөөцөлсөн болон ашиглалтгүй, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах боломжгүй бараа материал байхгүй байна.

Бараа материалын данс нь худалдан авсан 63.4 сая, бусад 154.7 сая төгрөгөөр нэмэгдэж, 73.3 сая төгрөгийн бараа материал зарцуулж, 310.6 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй тайлагнасан.

**Аудитын илрүүлэлт:**

- Шилжих хөрөнгө оруулалтын шилжүүлсэн дүнгээр эргэлтийн хөрөнгийн бүртгэлд тусгаагүй зөрчлийг залруулсан /ОНХС 110.9 сая/
- Шатахууны тайланг бэлтгэхдээ анхан шатны баримтын бүрдэл дутуу, даргын гарын үсэг хуулбарласан зөрчилд албан шаардлага өгсөн. /Баянтал сумын ИТХ 1.1 сая, Баянтал сумын ЗДТГ 7.6 сая/
- Бичиг хэргийн материалын тайланд анхан шатны баримтын бүрдэл дутуу зөрчилд албан шаардлага хүргүүлсэн /Баянтал ИТХ-0.2 сая/
- Аж ахуйн материалыг бүртгэхдээ дансны ангиллыг буруу тайлагнасан. Нярын бэлтгэсэн тайлан нягтлан бодогчийн бэлтгэсэн бараа материалын тодруулга тайлан зөрүүтэй илэрхийлэгдсэн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн./Баянтал сумын ЗДТГ 1.9 сая/

**3.5.5 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,188.4 сая, эцсийн үлдэгдэл 2,330.8 сая болж, 142.1 сая төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	1,237.6	1,237.6	0.0
Тээврийн хэрэгсэл	154.2	73.3	-81
Машин тоног төхөөрөмж	163.7	186.0	22.3
Тавилга эд хогшил	94.2	94.3	0.0
Түүх, соёлын дурсгалт зүйлс	0.0	0.0	0.0
Номын фонд	0.0	0.0	0.0
Бусад үндсэн хөрөнгө	457.1	657.9	200.8
Программ хангамж	3.0	3.0	0.0
Бусад биет бус хөрөнгө	78.6	78.6	0.0
<b>Дүн</b>	<b>2,188.4</b>	<b>2,330.8</b>	<b>142.1</b>

Эх сурвалж: "Баянтал сумын Засаг дарга"-ын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 2.6 сая, сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар 276.9 сая нийт 279.5 сая төгрөгөөр нэмэгдсэн, акталсан хөрөнгө 137.1 сая төгрөг, нийт 137.1 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд эхний, эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 73 нэр төрлийн 106 ширхэг 320.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлэх болон цаашид ашиглах боломжгүй хөрөнгийг актлах саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлээгүй, /ЗДТГ, ИТХ/

**3.5.6 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 1.3 сая, эцсийн үлдэгдэл 2.9 сая төгрөг болж 1.6 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	/сая төгрөг/ Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	1.3	2.9	2.9	100.0
Ажиллагчидтай холбогдсон өглөг	0.0	2.9	2.9	-
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.0	0.0	0.0	-
Бусад өглөг	1.3	0.0	-1.3	100.0
<b>Урт хугацаат өр төлбөр дүн</b>	-	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>1.3</b>	<b>2.9</b>	<b>1.6</b>	<b>100.0</b>

*Эх сурвалж: “Баянтал сумын Засаг дарга”-ын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Өмнөх оны богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд байгууллагад төлөх өглөг 1.3 сая төгрөгийг барагдуулсан. Тайлант онд ЗДТГ-ын АО-оос төлөх НДШ 2.9 сая төгрөгийн өглөг үүссэн байна. Өр төлбөр тооцоо нийлсэн актаар баталгаажсан байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд эхний, эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Тайлант хугацаанд цалин, НДШ-ийн тооцооллыг хянаж, тулгаагүйгээс санхүүжилтийн үлдэгдэлтэй, өр төлбөр үүсгэхгүй байх боломжтой байтал НДШ-д өглөг үүсгэсэн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн. /ЗДТГ 2.9 сая/
- Ажил гүйлгээг өглөгийн дансаар дамжуулан бүртгээгүй, шууд зардлаар тайлагнасан зөрчлийг аудитын явцад залруулсан. /ОНХС 344.2 сая/

**3.5.7 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 1,10.4 сая, эцсийн үлдэгдэл 1,585.0 сая болж, 474.6 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 7. Засгийн газрын хувь оролцоо*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/, бууралт /- /	Дүнд эзлэх хувь
----------	----------------	-----------------	-----------------------------	-----------------



**"Баянтал сумын Засаг дарга"-ын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Засгийн газрын оруулсан капитал	756.5	756.5	0.0	0.0
/Засгийн газрын сан/ орон нутгийн сан				
Өмч /төрийн/ /ТӨҮГ/				
Өмч /хувийн/ /ТӨҮГ/				
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/				
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/				
<b>Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/</b>				
Хуримтлагдсан үр дүн	353.9	828.5	474.6	100
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга				
<b>Дүн</b>	<b>1,110.4</b>	<b>1,585.0</b>	<b>474.6</b>	<b>100</b>

*Эх сурвалж: "Баянтал сумын Засаг дарга"-ын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,585.0 сая төгрөг болж 474.6 сая төгрөгөөр өссөн байна.

Эздийн өмчийн бусад хэсэг дансанд эхний, эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Хуримтлагдсан үр дүн 828.5 сая төгрөг болж 474.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

**Аудитын илрүүлэлт:**

*Засгийн газрын хувь оролцооны данстай холбоотой зөрчил илрээгүй байна.*

**3.5.8 Орлогын данс**

Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогод тус сумын Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлого 56.9 сая төгрөгийг тайлагнасан байна.

**Аудитын илрүүлэлт:**

*Орлого, үр дүнгийн тайланд зөрчил илрээгүй.*

**3.5.9 Зардлын данс**

Зардлын данстай холбоотой нэгтгэлд хамрагдсан харьяа байгууллагуудад нийт 19.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

**Аудитын илрүүлэлт:**

- *Сахилгын шийтгэлтэй албан хаагчид үр дүнгийн урамшуулал олгосон, жирэмсэн амаржсаны болон хүүхэд асрах чөлөөтэй байсан албан хаагчид ажил үүргээгүй гүйцэтгээгүй хугацааг харгалзан үзэлгүйгээр үр дүнгийн урамшууллыг бүтэн тооцож олгосон, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан албан хаагчдад үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгосон, үндэслэлгүйгээр урамшуулал олгосон, ХХС хариуцсан мэргэжилтэнд урамшууллыг илүү тооцож олгосон, томилолтын зардал олгохдоо албан хаагчид хоолны зардал давхардуулан олгосон, шатахууныг анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан, томилолтын хуудасны тэмдэг, гарын үсгийг хуулбарласан, хуурамч*

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

"Баянтал сумын Засаг дарга"-ын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байна.

##### **4.3.1 Харьяа байгууллагууд**

Харьяа төсвийн байгууллагуудад Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой зөрчил илрээгүй байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

"Баянтал сумын Засаг дарга" нь аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад зөрчил илрээгүй байна.

##### **4.4.1.1 Харьяа байгууллагууд**

Харьяа төсвийн байгууллагуудад Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад нийт 56.8 сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрсэн байна.

- Баянтал сумын ИТХ нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 13.6 сая төгрөгийн хөрөнгө зарцуулахтай холбоотой 4 тушаал шийдвэр, тодотгосон төсвийн хуваарийг мэдээлээгүй, нийт 19 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн
- Баянтал сумын ЗДТГ нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 39.6 мянган төгрөгийн 11 удаагийн хөрөнгө зарцуулах шийдвэрийг мэдээлээгүй, 31 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн
- Баянтал сумын ОНХС нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг 6 удаа мэдээлээгүй
- Баянтал сумын ХХС нь 3.6 сая төгрөгийн хөрөнгө зарцуулахтай холбоотой тушаал шийдвэрийг мэдээлээгүй.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

##### **4.4.2.2 Харьяа байгууллагууд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд дараах зөрчлүүд илэрлээ:

- Зарлагын гүйлгээг татварын цахим бүртгэлийн системээр шивэгдсэн эсэхийг тулгаагүйгээс Баянтал сумын ЗДТГ 4.9 сая төгрөгийн зөрүү үүссэн байна.
- Хариуцсан ажилдаа хариуцлагагүй хандаж анхан шатны баримтыг хуурамчаар бүрдүүлсэн, санхүүгийн баримт материалыг эмх цэгцгүй, хууль журмын дагуу архивлаж бэлтгээгүй, сахилга батгүй ажилласан нягтлан бодогч, нярав нарын зөрчилд сахилгын шийтгэл ногдуулах, хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн. /ЗДТГ, ИТХ/
- Хөрөнгийн хадгалалт хамгаалалт хангалтгүй, коджуулаагүй, жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг бодитой, үнэн зөв хийгээгүй. Өмч хамгаалах зөвлөлийн хяналтгүй, 2019 оноос хойш авсан газруудыг бүртгээгүй зөрчилд зөвлөмж өгсөн. /ЗДТГ/
- Албан хаагчдын ээлжийн амралтын тушаалыг гаргахдаа ажилласан жилийг үнэн зөв тооцоогүйгээс тушаалын хавсралтаар баталсан ээлжийн амралтын хоног, цалин бодсон ээлжийн амралтын хоногоос зөрүүтэй зөрчилд зөвлөмж өгсөн. /ЗДТГ/

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

“Баянтал сумын Засаг дарга”-ын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага					
Зөвлөмж	3	7.9	3	7.9	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>7.9</b>			

Өмнөх аудитаар 7.9 сая төгрөгийн 3 зөрчил илрүүлж, 7.9 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгч ажилласан. Хэрэгжилтийг хянаж үзэхэд биелэлт 100% байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 504.7 сая төгрөгийн 5 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан бөгөөд энэ нь Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэдэг харьяа байгууллагуудын алдаа байна.

Аудитаар нийт 171.3 сая төгрөгийн 35 зөрчил<sup>2</sup> илэрснээс 4.4 сая төгрөгийн 7 зөрчилд төлбөрийн акт, 123.3 сая төгрөгийн 15 зөрчилд албан шаардлага, 43.5 сая төгрөгийн 14 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнээс 129.8 сая төгрөгийн зөрчил нь харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн байна.

Залруулагдаагүй нийт зөрчлийн 171.3 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдлаас давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 41.4 сая төгрөгийн 3 зөрчил илрүүлснээс 41.4 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлээ.

### Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 3 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн, нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 2 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүврээр хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа 2 байгууллагуудын санхүүгийн тайланд "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 634.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 504.7 сая төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 4.4 сая төгрөгийн 7 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 65.2 сая төгрөгийн 9 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2.0 сая төгрөгийн 7 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Шилэн дансны тухай хууль, бусад хууль тогтоомжийн нийцлийн аудитаар 58.1 сая төгрөгийн 5 албан шаардлага, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж хүргүүлсэн байна. /Хавсралт 1-ээс үзнэ үү/

Өмнөх онтой харьцуулахад харьяа байгууллагуудын нийт зөрчлийн дүн төлбөрийн акт 2.0 сая төгрөгөөр, албан шаардлага 33.6 сая төгрөг, зөвлөмж 35.5 сая төгрөгөөр өссөн, нийцлийн аудитын албан шаардлагын дүн 133.5 сая төгрөгөөр буурсан байна.

Аудитаар өгсөн албан шаардлагын 46% буюу 56.8 сая төгрөг нь Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил байна. /Хавсралт 2-оос үзнэ үү/

### 5.1 Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт.

Төвлөрүүлэн захирагчид төлбөрийн акт хүргүүлээгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.